



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

### Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Засгийн газрын 2013 оны 38 дугаар тогтоолын 6 дахь заалт, 2020 оны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Барилгын политехник коллежийн 2019 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 25.9 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. Барилгын политехник коллежийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтын байдалд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Барилгын политехник коллежийн газар эзэмшилт, ашиглалтын байдал, газрын маргаантай, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, холбогдох бусад яам, агентлаг, байгууллагын эрх бүхий төлөөллийг оролцуулан зохион байгуулж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

3. Барилгын политехник коллежийн захирал Г.Нямдууламд санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг хэрэгжүүлж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах;

3.2. Барилгын политехник коллежийн дотоод хяналтыг зохион байгуулж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллах;

3.3. Байгууллагын нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, хөрөнгийн бүртгэл, хөтлөлт, тайлагналыг хууль тогтоомжид нийцүүлэх;

3.4. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд газар эзэмшилт ашиглалтын маргаантай асуудлыг шийдвэрлэх, төрийн өмчийн эзэмшил дэх төрийн өмчийн бус этгээдийн ашиглалтад байгаа газрыг чөлөөлүүлэх арга хэмжээ авч, шаардлагатай бол Газрын тухай хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу шүүх хяналтын байгууллагад хандах;

3.5. Сургуулийн газар эзэмшилт, ашиглалт, орц гарцтай холбоотой шалгалтын дүнгээр илэрсэн зөрчлийг арилгах талаар холбогдох байгууллагатай

132001329

хамтран зохих арга хэмжээ авч, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, байгууллагад шаардлагатай, хамаарал бүхий нийтийн эзэмшлийн зам талбайг баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

3.6. Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй, сууц өмчлөгчдийн ашиглалтад байгаа, мужааны цехийн 800 м.кв талбай бүхий газар эзэмших эрхийг холбогдох шийдвэрийг үндэслэн үндсэн хөрөнгийн данс бүртгэлээс хасуулах арга хэмжээ авах;

3.7. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн  
27 дугаар тогтоолын хавсралт



Барилгын политехник коллежид хийсэн шалгалтаар илэрсэн  
зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

| Д/д       | Шалгалтаар илэрсэн<br>зөрчил, дутагдлын утга   | Үнийн<br>дүн /сая<br>төгрөг/ | Зөрчигдсөн<br>эрхзүйн акт   | Цаашид авч<br>хэрэгжүүлэх арга<br>хэмжээний санал  |
|-----------|--|------------------------------|---|--|
| 1         | Байгууллагын сургалтын болон дадлагын байр, нийтийн эзэмшлийн зам талбай, авто зогсоолд автомашин нэвтрэх орц гарц байхгүй, эзэмшил газар дээр төрийн өмчийн бус хуулийн этгээд авто зогсоол, ЦТП байрлуулсан. | -                            | БНБД 21-01-02 норм дүрмийн 6.2, 6.3 дах заалт, Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоол              | Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол гарсан үед шуурхай албаны машин орж гарах зам гарц гаргах, газар эзэмшилтэй холбоотой зөрчлийг арилгах арга хэмжээ авч эрсдэлээс урьдчилан сэргийлэх                                  |
| 2         | Байгууллагын эзэмшил газраас сууц өмчлөгчдөд ашиглуулах зорилгоор шилжсэн, санхүүгийн тайланд бүртгэлтэй, биетээр байхгүй газар эзэмших эрхийг холбогдох шийдвэрийг үндэслэн данснаас хасаагүй.                | 25.9                         | Засгийн газрын 2013 оны 38 дугаар тогтоолын 6 дахь заалт, ТӨБЗГ-ын 2018 оны 367 дугаар тогтоол        | ТӨБЗГ-ын 2018.12.31-ний өдрийн А-1/4842, 2019.05.07-ны өдрийн А-5/1201 дугаар албан бичгээр сууц эзэмшигчдэд ашиглуулах зорилгоор нийтийн эзэмшилд шилжүүлэх асуудлыг дэмжиж газар эзэмших эрх шилжсэн тул данс бүртгэлээс хасах |
| 3         | Барилга байгууламжийн чанар байдал, ашиглалтыг сайжруулах урсгал болон их засвар хийж байх   | -                            | Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм БНБД 13-04-0-г | Жишиг нормын дагуу барилга байгууламжийн урсгал болох их засварын зардлыг эрх бүхий этгээдэд хандан төсөвт тусгуулах арга хэмжээ авч ажиллах   |
| НИЙТ ДҮН: |  | 25,9                         |   |  |